ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2025/018/НА-СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 98

танай _____-ны №_____ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ОРГИЛБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 15 дугаар тогтоолын дагуу "Нийгмийн даатгалын газар" болж өөрчлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс аймгийн Засаг даргын 2024 оны А/451 дугаар захирамжийн дагуу албан хаагчдад үндсэн цалингийн 25 хувиар тооцож сар бүр орон нутгийн нэмэгдэл олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Улсын төсвөөс санхүүжиж оны эцэст 193.0 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4625020240

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,932,902.00	15,320,270.00
34714	Томилолтын урьдчилгаа	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	12,932,902.00	15,320,270.00
35400	Хангамжийн материал	12,932,902.00	15,320,270.00
35410	Бичиг хэргийн материал	5,678,435.00	7,674,135.00
35420	Аж ахуйн материал	2,678,950.00	4,092,350.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,064,600.00	1,996,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	289,968.00
35470	Бусад хангамжийн материал	1,510,917.00	1,267,817.00
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,505,208,546.31	1,490,737,612.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,505,208,546.31	1,490,737,612.58
39200	Биет хөрөнгө	1,390,508,546.31	1,376,037,612.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,499,762,494.39	1,498,068,142.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(250,639,415.84)	(289,452,832.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,970,000.00	20,970,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,990,000.00)	(10,485,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	178,298,843.88	234,935,738.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,032,100.69)	(104,629,518.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,455,827.00	92,596,527.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,317,102.43)	(65,965,445.35)
39300	Биет бус хөрөнгө	114,700,000.00	114,700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	114,700,000.00	114,700,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,518,141,448.31	1,506,057,882.58
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,518,141,448.31	1,506,057,882.58
51	Засгийн газрын хувь оролцоо	1,518,141,448.31	1,506,057,882.58
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	453,350,001.77	453,350,001.77
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	453,350,001.77	453,350,001.77
51200	Хуримтлагдсан үр дүн	1,061,858,311.48	1,049,774,745.75
51210	Өмнөх үеийн үр дүн	1,061,858,311.48	1,061,858,311.48
51220	Тайлант үеийн үр дүн	-	(12,083,565.73)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,933,135.06	2,933,135.06
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,518,141,448.31	1,506,057,882.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН**	**1,412,871,000.52**	**1,927,587,414.00**
2	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**41,793,858.52**	**65,066,394.00**
3	**Нийтлэг татварын бус орлого**	**41,793,858.52**	**65,066,394.00**
4	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	**41,793,858.52**	**65,066,394.00**
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	41,778,558.52	64,015,554.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	15,300.00	1,050,840.00
7	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**1,371,077,142.00**	**1,862,521,020.00**

8	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**181,619,342.00**	**281,872,320.00**
9	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	181,619,342.00	271,534,520.00
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,337,800.00
11	**Төсвийн захирагчдаас**	**6,541,900.00**	**1,580,648,700.00**
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,580,648,700.00
13	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,541,900.00	-
14	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	**1,182,915,900.00**	**-**
15	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,182,915,900.00	-
16	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**1,479,842,214.03**	**1,939,670,979.73**
17	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,479,842,214.03**	**1,939,670,979.73**
18	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**1,086,210,064.02**	**1,544,771,098.42**
19	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**755,448,980.17**	**1,201,049,792.40**
20	Үндсэн цалин	462,504,136.48	565,608,457.79
21	Нэмэгдэл	187,017,405.76	375,607,037.11
22	Унаа хоолны хөнгөлөлт	37,842,999.67	49,963,999.50
23	Урамшуулал	68,084,438.26	209,870,298.00
24	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**95,490,935.80**	**151,421,688.36**
25	Тэтгэврийн даатгал	66,046,194.12	104,623,448.75
26	Тэтгэмжийн даатгал	7,824,608.51	12,009,014.56
27	ҮОМШӨ-ний даатгал	6,086,008.68	5,891,020.17
28	Ажилгүйдлийн даатгал	1,364,139.78	5,659,790.52
29	Эрүүл мэндийн даатгал	14,169,984.71	23,238,414.36
30	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**25,638,577.73**	**37,233,880.28**
31	Гэрэл, цахилгаан	5,070,479.51	5,322,499.96
32	Түлш, халаалт	17,397,038.22	20,728,030.32
33	Цэвэр, бохир ус	3,171,060.00	11,183,350.00
34	**Хангамж, бараа материалын зардал**	**43,938,238.29**	**19,961,859.65**
35	Бичиг хэрэг	8,571,613.00	8,441,650.00
36	Тээвэр, шатахуун	4,204,275.00	2,303,032.00
37	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,352,310.29	2,191,957.65
38	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
39	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,528,150.00	6,905,220.00
40	Бараа материал акталсны зардал	161,890.00	-
41	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**32,371,450.00**	**12,976,900.00**
42	Багаж, техник, хэрэгсэл	-	10,977,400.00
43	Урсгал засвар	32,371,450.00	1,999,500.00
44	**Томилолт, зочны зардал**	**8,554,000.00**	**11,191,600.00**
45	Дотоод албан томилолт	8,554,000.00	11,191,600.00
46	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**4,523,457.00**	**1,797,190.00**
47	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,291,800.00	563,000.00
48	Даатгалын үйлчилгээ	335,825.00	65,360.00
49	Тээврийн хэрэгслийн татвар	197,100.00	191,580.00
50	Газрын төлбөр	503,600.00	205,400.00
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	309,649.00	19,910.00

52	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	885,483.00	751,940.00
53	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**120,244,425.03**	**109,138,187.73**
54	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,449,699.00	21,361,500.00
55	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	116,794,726.03	87,776,687.73
56	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**393,632,150.01**	**394,899,881.31**
57	**Бусад урсгал шилжүүлэг**	**209,088,242.00**	**201,659,902.00**
58	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,875,000.00	7,643,190.00
59	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,100,400.00	51,272,912.00
60	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	104,523,800.00
61	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	156,112,842.00	38,220,000.00
62	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**-**	**193,239,979.31**
63	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	193,239,979.31
64	**Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**184,543,908.01**	**-**
65	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,543,908.01	-
66	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)**	**(66,971,213.51)**	**(12,083,565.73)**
67	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**(66,971,213.51)**	**(12,083,565.73)**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО**	**1,427,190,633.79**	**1,862,521,020.00**
2	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**1,378,701,623.50**	**1,862,521,020.00**
3	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**195,785,723.50**	**281,872,320.00**
4	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,166,381.50	-
5	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	181,619,342.00	271,534,520.00
6	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,337,800.00
7	**Төсвийн захирагчдаас**	**-**	**1,580,648,700.00**
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,580,648,700.00
9	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	**1,182,915,900.00**	**-**
10	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,182,915,900.00	-
11	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**1,424,118,984.68**	**1,853,230,820.00**
12	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,424,118,984.68**	**1,853,230,820.00**
13	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**1,036,878,383.78**	**1,458,330,938.69**
14	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**755,448,980.17**	**1,201,049,792.40**
15	Үндсэн цалин	462,504,136.48	565,608,457.79
16	Нэмэгдэл	187,017,405.76	375,607,037.11
17	Унаа хоолны хөнгөлөлт	37,842,999.67	49,963,999.50
18	Урамшуулал	68,084,438.26	209,870,298.00
19	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**95,490,935.80**	**151,421,688.36**
20	Тэтгэврийн даатгал	66,046,194.12	104,623,448.75
21	Тэтгэмжийн даатгал	7,824,608.51	12,009,014.56
22	ҮОМШӨ-ний даатгал	6,086,008.68	5,891,020.17
23	Ажилгүйдлийн даатгал	1,364,139.78	5,659,790.52
24	Эрүүл мэндийн даатгал	14,169,984.71	23,238,414.36
25	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**25,638,577.73**	**37,233,880.28**
26	Гэрэл, цахилгаан	5,070,479.51	5,322,499.96

27	Түлш, халаалт	17,397,038.22	20,728,030.32
28	Цэвэр, бохир ус	3,171,060.00	11,183,350.00
29	**Хангамж, бараа материалын зардал**	**48,488,375.29**	**23,660,927.65**
30	Бичиг хэрэг	12,033,265.00	10,437,350.00
31	Тээвэр, шатахуун	4,200,250.00	2,593,000.00
32	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,352,310.29	2,191,957.65
33	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,782,550.00	8,318,620.00
35	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**33,514,450.00**	**11,366,300.00**
36	Багаж, техник, хэрэгсэл	1,143,000.00	9,366,800.00
37	Урсгал засвар	32,371,450.00	1,999,500.00
38	**Томилолт, зочны зардал**	**8,554,000.00**	**11,191,600.00**
39	Дотоод албан томилолт	8,554,000.00	11,191,600.00
40	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**3,637,974.00**	**1,045,250.00**
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,291,800.00	563,000.00
42	Даатгалын үйлчилгээ	335,825.00	65,360.00
43	Тээврийн хэрэгслийн татвар	197,100.00	191,580.00
44	Газрын төлбөр	503,600.00	205,400.00
45	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	309,649.00	19,910.00
46	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**66,105,090.79**	**21,361,500.00**
47	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,449,699.00	21,361,500.00
48	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**387,240,600.90**	**394,899,881.31**
49	**Бусад урсгал шилжүүлэг**	**209,088,242.00**	**201,659,902.00**
50	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,875,000.00	7,643,190.00
51	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,100,400.00	51,272,912.00
52	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	104,523,800.00
53	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	156,112,842.00	38,220,000.00
54	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**-**	**193,239,979.31**
55	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	193,239,979.31
56	**Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**178,152,358.90**	**-**
57	Төвлөрүүлэх шилжүүлэг	178,152,358.90	-
58	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**3,071,649.11**	**9,290,200.00**
59	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ**	**-**	**9,290,200.00**
60	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**-**	**9,290,200.00**
61	**Дотоод эх үүсвэрээр**	**-**	**9,290,200.00**
62	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	9,290,200.00
63	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**-**	**(9,290,200.00)**
64	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**3,071,649.11**	**-**
65	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
66	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	453,350,001.77	2,933,135.06	1,061,858,311.48	1,518,141,448.31

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	453,350,001.77	2,933,135.06	1,061,858,311.48	1,518,141,448.31
Тайлант үеийн үр дүн	-	-	(12,083,565.73)	(12,083,565.73)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	453,350,001.77	2,933,135.06	1,049,774,745.75	1,506,057,882.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,580,648,700.00	1,387,408,720.69
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,580,648,700.00	1,387,408,720.69
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,415,876,800.00	1,223,968,818.69
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,159,000,100.00	1,009,421,888.74
5	Үндсэн цалин	660,320,100.00	565,608,457.79
6	Нэмэгдэл	304,736,000.00	287,654,428.69
7	Унаа хоолны хөнгөлөлт	65,252,000.00	49,963,999.50
8	Урамшуулал	128,692,000.00	106,195,002.76
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,073,400.00	127,610,872.02
10	Тэтгэврийн даатгал	97,713,400.00	88,333,992.09
11	Тэтгэмжийн даатгал	11,590,000.00	10,092,607.89
12	ҮОМШӨ-ний даатгал	5,795,000.00	4,932,816.87
13	Ажилгүйдлийн даатгал	5,795,000.00	4,724,610.85
14	Эрүүл мэндийн даатгал	23,180,000.00	19,526,844.32
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,771,800.00	37,233,880.28
16	Гэрэл, цахилгаан	13,756,600.00	5,322,499.96
17	Түлш, халаалт	35,910,100.00	20,728,030.32
18	Цэвэр, бохир ус	5,105,100.00	11,183,350.00
19	Хангамж, бараа материалын зардал	19,595,900.00	18,660,927.65
20	Бичиг хэрэг	10,456,000.00	10,437,350.00
21	Тээвэр, шатахуун	3,500,000.00	2,593,000.00
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,120,000.00	2,191,957.65
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	190,000.00	120,000.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,329,900.00	3,318,620.00
25	Эд хогшил, урсгал засварын зардал	20,657,900.00	20,656,500.00
26	Багаж, техник, хэрэгсэл	18,657,900.00	18,657,000.00
27	Урсгал засвар	2,000,000.00	1,999,500.00
28	Томилолт, зочны зардал	10,794,000.00	7,490,000.00
29	Дотоод албан томилолт	10,794,000.00	7,490,000.00
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,144,800.00	1,045,250.00
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,007,400.00	563,000.00
32	Даатгалын үйлчилгээ	490,500.00	65,360.00
33	Тээврийн хэрэгслийн татвар	196,200.00	191,580.00
34	Газрын төлбөр	206,000.00	205,400.00
35	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	244,700.00	19,910.00
36	Бараа үйлчилгээний бусад зардал	2,838,900.00	1,849,500.00
37	Бараа үйлчилгээний бусад зардал	975,000.00	-
38	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,863,900.00	1,849,500.00
39	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,771,900.00	163,439,902.00

40	Бусад урсгал шилжүүлэг	164,771,900.00	163,439,902.00
41	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,756,300.00	7,643,190.00
42	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,491,800.00	51,272,912.00
43	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	104,523,800.00	104,523,800.00
44	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,580,648,700.00	1,387,408,720.69
45	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,580,648,700.00	1,387,408,720.69

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
1	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО**	**281,872,320.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**281,872,320.00**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**281,872,320.00**
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	271,534,520.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,337,800.00
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**281,872,320.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**281,872,320.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**243,652,320.00**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**191,627,903.66**
210102	Нэмэгдэл	87,952,608.42
210104	Урамшуулал	103,675,295.24
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**23,810,816.34**
210201	Тэтгэврийн даатгал	16,289,456.66
210202	Тэтгэмжийн даатгал	1,916,406.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	958,203.30
210204	Ажилгүйдлийн даатгал	935,179.67
210205	Эрүүл мэндийн даатгал	3,711,570.04
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**5,000,000.00**
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00
2107	**Томилолт, зочны зардал**	**3,701,600.00**
210702	Дотоод албан томилолт	3,701,600.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**19,512,000.00**
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,512,000.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**38,220,000.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**38,220,000.00**
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,220,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,531.5 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 25,531.5 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

-Тайлант хугацаанд нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээний 25,531.5 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагаар тусгасан байна.

Аудитаар нийт 8 зөрчил[2] илэрснээс 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт нягтлан бодох бүртгэл хөтлөлт сайжруулахтай холбоотой 6 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

1. Бараа материалын тайлан, орлого, зарлагын баримт, шаардах хуудсыг тухай бүр хөтлөөгүй, хянуулж баталгаажуулахгүйгээр 29,379.2 мянган төгрөгийн төсвийн өмч хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын Гурав. Бараа материалын үнэт зүйлийн маягтыг нөхөх заавар"-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Алба хаагчдад албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгохдоо томилолтын хуудсыг бүрэн хөтлөөгүй, томилолтын тайлан бичээгүй, ажилласан хоног, ирсэн, явсан өдрийг тэмдэглээгүй бүрдэл дутуу баримтаар 4,520.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж, хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4. "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно"-д гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Байгууллагын даргын 2024 оны А/34 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого зохион байгуулах комисс томилсон боловч тооллогын үр дүнг тайлагнаагүй, эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг НХМаягт БМ-8 маягтаар хөтлөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 "*эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах",* 72.4.4 *"комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын*

---

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

2 Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 8-д */... хөрөнгийн тооллогын бүртгэлд байгууллагын нэр, эд хөрөнгийн нэр төрөл, хаана ашиглагдаж байгаа, хөрөнгийн чанар байдал зэргийг тэмдэглэхийн хамт тооллогын бүртгэлийн хуудас бүрийн ард тооллогын комиссын дарга, гишүүд, эд хариуцагч гарын үсэг зурна/* -д заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, агуулахын эмх цэгцийг сайжруулах, анхан шатны бүртгэлийн маягтыг бүрэн хөтлөх, бараа материалын үлдэгдлийг тоолж тулган баталгаажуулах, хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулж ажиллах зөвлөмж хүргүүлэх

Илрүүлэлт: 2 НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дүгээр" Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" тушаалтай холбоотойгоор ажлаас чөлөөлөгдсөн Цогтцэций сумын Нийгмийн даатгалын тасагт үйлчлэгчээр 6 жил ажилласан Т.Бадамцэцэгт хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 *"Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно"*, 82.1.3 "*тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх"*-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу Т.Бадамцэцэгт хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг нөхөж олгох, санхүүгийн тайланд өглөгөөр тусгах зөвлөмж хүргүүлэх

Илрүүлэлт:3 Ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй Гүний ус ХК-д гадна шугам сүлжээний засварт 7,260.0 мянган төгрөг, ЭММЗ-ийн сургалтын брошурт Баткон говь ХХК-д 2,695.0 мянган төгрөг тус тус олгож, гүйцэтгэсэн ажлын тайланг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 "анхан шатны баримт*" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*", 13 дугаар зүйлийн 13.7 "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг гарсныг нотлох анхан шатны баримтын бүрдлийг хангаж төлбөр тооцоо гүйцэтгэх зөрчлийг давтан гаргахгүй байх

Илрүүлэлт:4 "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас" болон илүү цагийн бүртгэл хөтлөөгүй, төсвийн захирагч өөрийг оролцуулан нийт 6,790.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын Гурав. Нэмэгдэл хөлс олгох 1-т *"Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ*" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна..

Өгсөн зөвлөмж: Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа ажил гүйлгээг хэрэгжүүлж ажиллах

Илрүүлэлт:5 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон 5,000.0 мянган төгрөгийг Ворлдгоби групптэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан шилжүүлсэн ч гэрээний дагуу ажил хэрэгжүүлсэн эсэх нь гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлангаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",* 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг тооцож акт үйлдэж хэвших

Илрүүлэлт:6 Тус газар нь 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нүүрийг Сангийн сайдын 2023 оны А/229, санхүү байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэл, бараа материалын тодруулга тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал, өмчийн өөрчлөлт, үндсэн хөрөнгийн тодруулга тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал гэсэн толгойтой хэвлэлийн формат стандарт бус, зарим мөр, үзүүлэлтийг дутуу бэлтгэн ирүүлсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг батлагдсан заавар журмын дагуу бэлтгэх, программ хангамжийг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын тайлан, орлого, зарлагын баримт, шаардах хуудсыг тухай бүр хөтлөөгүй, хянуулж баталгаажуулахгүйгээр 29,379.2 мянган төгрөгийн төсвийн өмч хөрөнгө зарцуулсан байна.	1	0			1	0						
Алба хаагчдад албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгохдоо томилолтын хуудсыг бүрэн хөтлөөгүй, томилолтын тайлан бичээгүй, ажилласан хоног, ирсэн, явсан өдрийг тэмдэглээгүй бүрдэл дутуу баримтаар 4,520.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж, хөрөнгө зарцуулсан байна.	1	4,520.0			1	4,520.0						
Байгууллагын даргын 2024 оны А/34 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого зохион байгуулах комисс томилсон боловч тооллогын үр дүнг тайлагнаагүй, эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг НХМаягт БМ-8 маягтаар хөтлөөгүй байна.	1	0					1	0				
НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дүгээр" Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" тушаалтай холбоотойгоор ажлаас чөлөөлөгдсөн Цогтцэций сумын Нийгмийн даатгалын тасагт үйлчлэгчээр 6 жил ажилласан Т.Бадамцэцэгт хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг олгоогүй байна.	1	2,700.0					1	2,700.0				
Ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй Гүний ус ХК-д гадна шугам сүлжээний засварт 7,260.0 мянган төгрөг, ЭММЗ-ийн сургалтын брошурт Баткон говь ХХК-д 2,695.0 мянган төгрөг тус тус олгож, гүйцэтгэсэн ажлын тайланг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.	1	0					1	0				

Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас” болон илүү цагийн бүртгэл хөтлөөгүй, төсвийн захирагч өөрийг оролцуулан нийт 6,790.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.	1	6,790.4					1	6,790.4				
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон 5,000.0 мянган төгрөгийг Ворлдгоби групптэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан шилжүүлсэн ч гэрээний дагуу ажил хэрэгжүүлсэн эсэх нь гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлангаар нотлогдохгүй байна.	1	5,000.0					1	5,000.0				
Тус газар нь 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нүүрийг Сангийн сайдын 2023 оны А/229, санхүү байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэл, бараа материалын тодруулга тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал, өмчийн өөрчлөлт, үндсэн хөрөнгийн тодруулга тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал гэсэн толгойтой хэвлэлийн формат стандарт бус, зарим мөр, үзүүлэлтийг дутуу бэлтгэн ирүүлсэн байна.	1	0					1	0				
Дүн	**8**	**19,010.4**			**2**	**4,520.0**	**6**	**14,490.4**				

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн
Тайлант хугацаанд нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээний 25,531.5 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагаар тусгасан байна.	1	**25,531.5**			1	**25,531.5**	1	**25,531.5**				
Дүн	1	**25,531.5**		1	1	**25,531.5**	1	**25,531.5**				